

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019.06.17

№

Дархан

Аймгийн Засаг даргын Шуурхай хурал 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 08:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хуралдааны танхимд эхлэв. Сум, хэлтэс, агентлагийн удирдлагууд 2019 оны 06 дугаар сарын 10-14-ний өдрүүдэд зохион байгуулсан ажил болон 2019 оны 06 дугаар сарын 17-21-ний өдрүүдэд хийж хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл хийв.

Аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинбат: ЧИГЛЭЛ, ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Нийт удирдлагууд: Өнгөрсөн 7 хоногт сайд нартай байгуулсан үр дүнгийн гэрээний 2019 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийг явуулж эхэлсэн. Сайдтай байгуулсан гэрээний биелэлтэд 30 хувийн гүйцэтгэлтэй 5 арга хэмжээ явсан. Мөн сайдай байгуулсан гэрээний хангалтгүй үнэлэгдсэн зүйл, заалтуудын хэрэгжилтэд анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Аймгийн Засаг дарга С.Насанбат: ЧИГЛЭЛ, ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Нийт удирдлагууд: Монгол улсын Ерөнхий сайд Дархан-Уул аймагт Дархан Улаанбаатар чиглэлийн авто замын нээлтийн үйл ажиллагаанд оролцохоор өнөөдөр ирэх гэж байна. Аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга оролцоо хангаж ажиллана. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах хэрэгтэй байна. Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл ажлыг сайн хангаж ажиллах хэрэгтэй байна. Урьдчилсан шалгалтаар Шарын гол, Орхон суманд ажиллахад хангалтгүй үнэлгээ авсан байна. Алдаа, дутагдлыг засаж сайжруулж ажиллах хэрэгтэй байна. Иймд Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Алтанчимэг хангалтгүй үнэлгээ авсан байгууллагуудад хугацаатай үүрэг даалгавар өгч үр дүнг нь дараагийн аймгийн Засаг даргын Шуурхай хуралд танилцуулах хэрэгтэй байна. Элсэлтийн ерөнхий шалгалт өнөөдөр эхэлж байна. Элсэлтийн ерөнхий шалгалтын зохион байгуулалтад сайн анхаарч ажиллах хэрэгтэй байна. Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Төрийн албаны тухай хуулийн дагуу цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирлууд болон бусад холбогдох албан тушаалтнуудыг сонгон шалгаруулалтад хяналт тавьж ажиллах хэрэгтэй байна. Ингээд 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр болоход орон тоо нь суларсан сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын сонгон шалгаруулалт дуусч ажилдаа орсон байх ёстой. Өнгөрсөн 7 хоногт БСШУЯ-ны сайд Дархан-Уул аймагт ажиллах үеэр боловсролын байгууллагын ажилтнуудын хэлсэн санал, шүүмжлэлд анхаарч ажиллах хэрэгтэй байна. Мэдээлэл, технологийн алба аймаг, орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын талаарх мэдээллийн талаар иргэд, олон нийтэд түргэн шуурхай хүргэж байх хэрэгтэй байна. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс Найрамдал талбайн тохижилтын ажлын зураг төсвийг боловсруулалтад хяналт тавьж ажиллах хэрэгтэй байна. 2020 оны хамгийн эхний тендер зарлах ажил бол талбайн тохижилт байна. Иймд уг ажлын зураг төсвийг хийгээд магадлалаар оруулаад тендерийг нь зарлах хэрэгтэй. 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр уг ажлыг эхлүүлнэ. Мөн талбайн тохижилтын ажил, гэрэлтүүлгийн ажилд анхаарах хэрэгтэй байна. Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах ажлын хүрээнд салбар хороо, ажлын хэсэг ажлаа эрчимжүүлэх хэрэгтэй байна.

Хурал 10 цаг 20 минутад дуусав.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС